

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАГНАЛ**

2025.07.26

Борхойн тал

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-нээс 2025 оны 06 дугаар сарын 30		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Э-Транс ложистикс ХК, ETR, 99117631		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Хөрөнгийн бирж ТӨХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Ачаа тээвэр, гаалийн нэг цэгийн үйлчилгээ		
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	ИХМОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК, 2014 оны 09 дүгээр сарын 17		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	46,200,000 ширхэг		
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайлан бэлтгэсэн: Дотоод ажил хариуцсан ажилтан С.Ганбат Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Энхболд		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн		4,349,006,136.89
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн		4,952,357,749.15
	Нийт хөрөнгийн дүн		9,301,363,886.04
	Богино хугацаат өр төлбөрийн дүн		172,875,639.97
	Урт хугацаат өр төлбөрийн дүн		3,057,946,926.59
	Өр төлбөрийн нийт дүн		3,230,822,566.56
	Эзэмшигчдийн өмчийн дүн		6,070,541,319.48

		Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	9,301,363,886.04
Орлогын тайлан		Борлуулалтын орлого (цэвэр)	1,646,386,968.74
		Нийт ашиг (алдагдал)	1,646,386,968.74
		Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	147,597,619.45
		Татварын дараах ашиг (алдагдал)	132,004,330.90
		Нийт орлогын дүн	132,004,330.90
Өмчийн өөрчлөлтийн тайлан		Өмч	4,620,000,000.13
		Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00
		Эздийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00
		Хуримтлагдсан ашиг	521,683,239.35
		Нийт дүн	6,070,541,319.48
Мөнгөн гүйлгээний тайлан		Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	1,831,820,281.12
		Мөнгөн зарлага (-)	1,579,753,037.89
		Цэвэр мөнгөн гүйлгээ	252,067,243.23
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Мөнгөн орлогын дүн (+)	4,802,735.00
		Мөнгөн зарлагын дүн (-)	47,884,600.24
		Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-43,081,865.24
		Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
		Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-81,394,645.07
		Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	127,59,732.92
		Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,816,102,002.17
2.	Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
	Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 08-ний 03 тоот тогтоолоор тус зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Ж.Энхтулга, Ш.Мөнхбаатар, Э.Уянга нарын бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Тус хорооноос компанийн санхүүгийн тайланг жилд нэг удаа жилийн эцсээр хэлэлцэхээр шийдвэрлэсний дагуу хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцээгүй болно.		

3. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт

2025 оны эхний хагас жилийн байдлаар тус компанийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа ноцтой нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл байхгүй. Гаалийн хяналтын бүсэд нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 2509-өөр өссөн, мөн 2024 онд чингэлгээр орж ирж байгаа тээврийн хэрэгсэл 5 сараас эхлэн тус гаалийн хяналтын бүсэд орж ирж эхэлсэн бол энэ онд оны эхнээс орж ирж бууж байснаараа давуу талтай байсан ба 540,4 сая төгрөгийн ашигтай ажилласан зэргээс шалтгаалан зарим төрлийн үйлчилгээнээс алдсан алдагдлыг нөхөж байлаа. Алдагдалд хүргэж байгаа гол нөхцөл байдал бол үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа үндсэндээ бүрэн зогсонги байдалтай байснаас шалтгаалсан гэж үзэж болно. Энэ нь төмөр замаар тээвэрлэлт хийх иргэд аж ахуйн нэгжийн хүсэл сонирхол, УБТЗ-ийн бодлого зэрэг хүчин шалтгаанаас болж байгаа гэж үзэж болно. 2024 оны хагас жилийн байдлаар 119 вагон ачаа шилжүүлэн ачиж байсан бол 2025 онд 10 вагон ачаа шилжүүлэн ачсан байх ба энэ үйл ажиллагаанаас 236,4 сая төгрөгийн алдагдал хүлээсэн. Компанийн удирдлагын зүгээс энэхүү нөхцөл байдлыг дүгнэн гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагаандаа гол анхаарлаа хандуулан хэрэглэгч татах, хяналтын бүсийн зай талбайг нэмэгдүүлэх, засварлах зэрэг ажлуудыг шат дараалалтай хийж хэрэгжүүлж ажиллаж байгаа ба 2024 онд 3440м² талбайг өөрийн эзэмшилд худалдан авсан бөгөөд нэмж газар худалдан авах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.

д/д	Орлого	2024 оны хагас жил	2025 оны хагас жил	Зөрүү
1	Ачилтын орлого	327,201,627	13,610,545	-95.8%
2	Хадгалалт болон гарах хуудасны орлого	856,700,755	1,037,757,526	21.13%
3	Түрээсийн орлого	30,575,758	27,200,000	-11.04%
4	Бусад орлого	271,843,403	685,040,366.17	2,5 дахин өссөн

2025 оны хагас жилийн байдлаар компанийн орлогын хэмжээ 2024 оны мөн үеийнхтэй харьцуулахад зарим үзүүлэлтээр алдагдалтай байгаа боловч бусад орлогоос олж байгаа орлого эдгээр алдагдалийг нөхөу жилийн эцэст өмнөх оны хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах бүрэн боломжтой байгаа юм.

3.1. Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/

Нийт ашгийн хувь: Үйл ажиллагаанд өртөг тооцдоггүй
Ахиуц цэвэр ашиг : 8.02%
Цэвэр ашиг : 132.0 сая
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 2.86%
Эргэлтийн харьцаа: 25.1
Түргэн хөрвөх чадварын харьцаа: 20.7

3.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

Хөрөнгийн байдлын үнэлгээ\		
Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
	2025 оны хагас жил	
Хөрөнгийн ачаалал	1.53	1 төгрөг тутамд ногдох хөрөнгийн ашиглалтын байдал
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	46.7	Эргэлтийн хөрөнгийн эзлэх жин өмнөх тайлант үеэс нэмэгдэж сайжирсан, үндсэн хөрөнгийн жин өндөр хэвээр.Нийт хөрөнгийн 46.7 хувь нь эргэлтийн хөрөнгө байна.
Элэгдлийн хувь	39.4%	Үндсэн хөрөнгийн элэгдлийн хувь 39.4% хувь
Санхүүгийн байдлын үнэлгээ		
Төрөл	Үзүүлэлт	Дүгнэлт
	2025 оны хагас жил	
Ажлын капитал	4 176 130 500	Ажлын капитал сайн ба эргэлтийн харьцаа 25.1 байгаа нь үйл ажиллагаанд богино хугацааны санхүүгийн дарамт байхгүйг илэрхийлж байна.
Өрийн харьцаа	34.5	Санхүүгийн эрсдлийн түвшинг харуулдаг. Нийт хөрөнгийн 40хувь нь өрөөр санхүүжигдэж байна. Хөрөнгө оруулагчид банкны салбарынханд энэ үзүүлэлт их чухал. 34.5 нь хэвийн түвшинд байна.
Эргэлтийн харьцаа	25.1	Эргэлтийн хөрөнгөөр БХӨТ-ийг барагдуулах чадвар сайн.
Бие даалтын коеф	65.2	Компанийн нийт хөрөнгийн 65,2 хувийг эзэд өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлсэн үлдсэн. 34.8 хувийг өрийн эх үүсвэртэй.

3.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

	Компанийн хувьд тухайн бүс нутагт гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс газар нутгийн байрлал, хяналт шалгалт хийх нөхцөл байдал, баталгаат агуулахын үйл ажиллагаа, салбар төмөр зам зэрэг нөхцлүүдээр давуу талтай байдаг бөгөөд энэ байдлаа ашиглан ажиллахад үйл ажиллагаа хангалттай хэмжээнд явах боломжтой компани юм. Гадаад дотоодоос аж ахуйн нэгжид үзүүлэх нөлөө ихтэй байдгаас зарим тохиолдолд гаалийн хяналтын бүсэд машин хуваарьлахгүй байх, төмөр замд вагон тавьж олгохгүй байх, ачаа бараа хүлээн авагч гаалийн хяналт шалгалтанд хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн хууль бус үйлдлээс шалтгаалж ачаа бараа гаргахгүй удаах зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж компанийн үйл ажиллагаа сар бүр өөрчлөгдөж түүнд тохирсон хариу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар компанийн үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа үндсэндээ зогсонги байдалтай байгаа ба 2025 он гарсаар 10 вагон төмөр ачиж, 3 вагон хуванцарыг тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачсан байдалтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 109 вагоноор цөөн байгаа юм. Иргэд аж ахуйн нэгжүүдээс төмөр замаар тээвэр хийхийг чухалчилахгүй автозамаар тээвэр хийх сонирхол ихтэй болсноос энэхүү нөхцөл байдалд оруулж байгаа учраас зөвхөн энэ чиглэлд ажлаа төлөвлөх бус ачаа барааны эргэлт сайн байгаа гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахынхаа үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулан ажиллахаар төлөвлөж ажиллаж байна.	
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Сонирхолын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл	
	Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.	
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 сарын 29-ний өдөр “ БиДиСек ҮЦК “ ХК-ийн цахим хурлын системээр дамжуулан зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн: Компанийн 2024 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	

	ТУЗ-ийн 2025 оны цалин урамшууллын төсөв батлах ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийг танилцуулах - Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шинээр Э.Ариунтуяа, Э.Уянга, А.Гэрэлцогт нар ердийн гишүүнээр, Ш.Мөнхбаатар хараат бус гишүүнээр шинээр сонгогдон бусад гишүүд улиран сонгогдсон бөгөөд гишүүдийн хурлыг 2025 оны 07 дугаар сарын 07-ний өдөр эчнээгээр зохион байгуулан төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, зөвлөлийн дэргэдэх хороодын гишүүдийг шинэчилж томилсон. Тухайн гишүүдийг томилохдоо компанийн засаглалын кодексийг баримтлан хороодын даргыг хараат бус гишүүдээр томилсон болно. . - 2024 оны жилийн санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд Их Монгол хөлөг аудит ХХК-иар аудит хийлгэн аудитын дүгнэлт тайлагналыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар аудитын компанийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. - Компанийн цахим хуудсыг тогтмол шинэчлэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох мэдээллээр ханган ажилласан. Цаашид цахим хуудас болон сошиал хуудаснуудын байнгын ажиллагааг хангаж ажиллахад анхаарч ажиллаж байна. - Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлагналуудыг хууль журмаар тогтоосон хугацаанд нь гарган Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэн ажиллаж байгаа ба Хөрөнгийн биржийн цахим хуудсанд тайлагналуудыг тогтмол байршуулж байна. - Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланг Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж үнэлэлт дүгнэлт өгүүлж ажилласан.	
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл	
	Засаглалын үнэлгээний тайланг холбогдох журам зааварт заасныг баримтлан гаргаж хүргүүлсэн.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Чулуун Энхболд Албан тушаал: "Э-Транс ложистикс" ХК-ийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)		Овог, нэр: Албан тушаал: "Их Монгол хөлөг аудит" ХХК аудитын компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/тэмдэг)
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Содномцэрэн Ганбат Албан тушаал: Дотоод ажил, хяналт хариуцсан ажилтан		

Гарын үсэг: *[Signature]*